



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 дугаар
сарын 09 -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот
Утас: 262629

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөр”-ийг батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1, Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг гуравдугаар, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг тавдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батцэцэг/-т, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т, хэрэгжилтийг хангаж, хөтөлбөрийн үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД



А.АРИУНЗАЯА